

ӨГҮҮЛЭЛ

АНУ-БНХАУ-ын худалдааны дайн, дэлхийн эдийн засагт үзүүлсэн нөлөө

Лугуушаравын Бямбаханд*

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан
byambakhand.l@mas.ac.mn*

Буджавын Болормаа

*МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш
bolormaa.b@num.edu.mn*

Хураангуй: АНУ-ын Ерөнхийлөгчийн 2016 оны сонгуульд “Америкийг дахин агуу болгоё” гэсэн мөрийн хөтөлбөртэй оролцсон Д.Трампа ялалт байгуулж, өөрийн гадаад бодлогыг “Америкийг эн тэргүүнд тавих” хэмээн тодорхойлсон юм. Улмаар тэрээр олон жилийн туршид асар их алдагдалтай явж ирсэн Америкийн гадаад худалдааны балансыг тэнцвэржүүлэх зорилт дэвшүүлсэн нь АНУ-БНХАУ-ын худалдааны дайн гарахад нөлөөлсөн. Энэ дайн нь Вашингтон, Бээжингийн эдийн засагт нөлөөлөөд зогсохгүй дэлхийн эдийн засгийг доргилтонд оруулаад байна.

Толилуулан буй өгүүллийн эхний хэсэгт худалдааны дайны тухай ойлголтыг авч үзэх бол хоёрдугаар хэсэгт АНУ-БНХАУ-ын хооронд өрнөсөн худалдааны дайны үүсэл, шалтгаан, өрнөл, энэ дайныг түр зогсоогоод байгаа хоёр улсын худалдааны хэлэлцээрт дүн шинжилгээ хийнэ. Өгүүллийн төгсгөлд, АНУ-БНХАУ-ын худалдааны дайн нь хоёр улсын эдийн засагт төдийгүй дэлхийн эдийн засагт үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлийн талаар дүн шинжилгээ хийсэн болно.

Түлхүүр үгс: АНУ, БНХАУ, худалдааны дайн, дэлхийн эдийн засаг, тариф

* Corresponding author



Нэг. Худалдааны дайны тухай ойлголт

Аливаа тусгаар улсад худалдааны салбарт бусад улстай харилцах гадаад худалдааны тусгай бодлого байдаг. Энэхүү бодлого нь тухайн улсын бусад оронтой тогтоосон худалдааны харилцааг хөгжүүлэхэд чиглэж, дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдаанаас хамгаалсан оновчтой шийдвэрүүдийг гаргахад тусладаг. Өөрөөр хэлбэл, экспорт, импортын хэмжээгээ зохицуулж, өөрийн орны эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэлүүдийн нийлбэр юм. Улс орнууд гадаад худалдааны бодлогодоо ерөнхий хоёр гол чиглэлийг баримталдаг.

1. Чөлөөт худалдааны бодлого-

Гадаад худалдаанд төрийн оролцоог хязгаарлах, зах зээлийг зохицуулах төрийн үүрэг оролцоог эрс багасгахад чиглэсэн бодлого юм. Гадаад худалдаанд төрийн оролцоог багасгана гэдэг нь төр эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохгүй гэсэн үг биш. Төр ямар хэмжээнд оролцож буйгаас хамаарч энэ нь протекционист бодлогоос ялгардаг. Чөлөөт худалдаа нь улс төрийн тааламжтай байдлыг үүсгэн, улс орнууд бие биеэсээ харилцан хамаарах хамаарлыг нэмэгдүүлснээр нэг талаар улс төрийн хамгаалалтыг бий болгодог. Өөрөөр хэлбэл, жижиг эдийн засагтай улсын тухайд худалдааны алдагдал хүлээж

болох боловч чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлснээр улс төрийн хувьд хамгаалалттай болж байгаа хэрэг хэмээн үзэх нь бий.¹

2. Протекционист бодлого –

Гадаад худалдаанд төрийн оролцоо өндөр, дотоодын үйлдвэрлэл болон шинээр үүсч буй салбараа гаднын өрсөлдөөнөөс хамгаалах бодлогыг түлхүү хэрэгжүүлнэ гэсэн үг. Энэхүү бодлогыг гаалийн татвар, тарифын бус хориг саадуудаар дамжуулан хэрэгжүүлдэг.²

Энэ хоёр ерөнхий бодлогыг хослуулсан бодлого байдаг нь худалдааны холимог бодлого юм. Өөрөөр хэлбэл, чөлөөт худалдааны болон протекционист бодлогын холимог гэсэн үг. Гаалийн татвараар дотоодын эдийн засгийн тодорхой хэсгийг бүрдүүлж, мөн шаардлагатай дотоодын үйлдвэрлэлээ гадаад бодлогоороо хамгаалахаас гадна хэрэгцээтэй бүтээгдэхүүний тухайд чөлөөт худалдааны бодлого баримтална гэсэн үг юм.

Улс хоорондын худалдааг зохицуулах үүрэг бүхий олон улсын байгууллага болох Дэлхийн худалдааны байгууллага нь чөлөөт худалдааг дэмжин ажилладаг. Өөрөөр хэлбэл, энэхүү байгууллагад нэгдэн орохын тулд тухайн улс орон нь тодорхой хэмжээнд чөлөөт худалдааны бодлого баримталдаг

1 Robert Z. Lawrence, Lawrence Edwards “Shattering the Myths About U.S. Trade Policy”, *Harvard Business Review* (March 2012)

2 Robert Z. Lawrence, Roberts E. Litan “Why Protectionism Doesn’t Pay”, *Harvard Business Review* (May 1987)

байх ёстой. Гэсэн хэдий ч гишүүн орнууд нь зарим тохиолдолд дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, худалдааны алдагдлаа бууруулах, ажилгүйдлийн түвшинг барих гэх мэт дотоодын тулгамдсан асуудлаа шийдвэрлэхийн тулд зарим тохиолдолд протекционист бодлого баримталдаг. Чухам энэ нь “худалдааны дайн” эхлэх шалтгаан болдог.

Худалдааны дайн гэдэг нь хоёр болон түүнээс дээш тооны орныг хамарсан худалдаанаас үүдсэн эдийн засгийн дайн юм. Энэ дайнд улс орнууд гаалийн татварыг нэмэгдүүлэх, хориг саад тавих зэргийг зэвсэг болгон ашигладаг. XV- XVIII зуунд давамгайлж байсан меркантилизмын онолтой худалдааны дайны үүсэл холбогдоно. Энэхүү онол нь улс орныхоо баялгийг нэмэгдүүлэхийн тулд экспортоо нэмэгдүүлж, импортоо хязгаарлахыг илүүд үздэг. Ингэхдээ бусад улсын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүнд тариф ногдуулах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, мөнгөний нийлүүлэлтд хатуу хяналт тавих зэрэг арга хэмжээ авдаг.³ Импортын барааны тарифыг нэмэгдүүлснээр тухайн бүтээгдэхүүн зах зээлд өндөр үнэтэй болж, улмаар хэрэглэгчид орлуулах дотоодын бүтээгдэхүүнийг сонгох нь нэмэгдэнэ гэх логикт үндэслэлээр худалдааны дайныг өдөөдөг.⁴

Дэлхийн түүхэнд худалдаанаас үүдэлтэй олон дайн, мөргөлдөөн гарч байсан. Эдгээрээс хамгийн томд тооцогдох гурван том худалдааны дайныг энд дурдая. Үүнд:⁵

1. Франц–Италийн худалдааны дайн: 1871 онд Итали нэгдмэл улс болсноос хойш худалдааны протекционист бодлого баримтлах болсон. Үүнээс улбаалан 1886 онд Франц улстай хийсэн худалдааны хэлэлцээрээ цуцалж, харилцан гаалийн татвараа нэмснээр худалдааны дайн анх эхэлсэн түүхтэй.⁶

2. Канад–Америкийн худалдааны дайн: АНУ гадаад худалдааны протекционист бодлого баримтлахаар шийдвэрлэснээр уг худалдааны дайн эхэлсэн. 1854 онд Канад улстай байгуулсан “харилцан дэмжих гэрээ” буюу гаалийн татвараа тэглэсэн хэлэлцээрээ 1866 онд цуцалсан. Гэрээг цуцалсны дараа Канадаас импортолдог барааны гаалийн татварыг нэмсэн. Канад улс ч мөн 1879 онд протекционист бодлого хэрэгжүүлж эхлэн, сөрөг арга хэмжээ авч, гаалийн татвараа нэмжээ. 1890 онд АНУ Уильям Мак Кинлейгийн санаачилж, түүний нэрээр нэрлэсэн “Мак Кинлейгийн хууль”-ийг баталж, гаалийн татварыг 38 хувиас 49.5 хувь хүртэл нэмэгдүүлж, 1897 онд

3 Big Think “Mercantilism: The theory that explains Trump’s trade war” <https://bigthink.com/politics-current-affairs/donald-trump-trade-mercantilism?rebelltitem=4#rebelltitem4>

4 Review “Global trade war: the background, the theory, winners and losers” (July 24, 2018) <https://apngroup.com.au/blog/global-trade-war-the-background-the-theory-winners-and-losers/>

5 JPMorgan “What is a trade war and are in one?” https://am.jpmorgan.com/blob-gim/1383557340865/83456/PI-TRADEWAR_r9.pdf

6 Frank J. Coppa, “The Italian Tariff and the Conflict Between Agriculture and Industry: The Commercial Policy of Liberal Italy, 1860-1922” *The Journal of Economic History* Vol. 30, No. 4 (Dec., 1970), pp. 742-769

Нелсон Динглейгийн санаачилсан “Динглейгийн хууль”-ийг баталж, татварыг дахин нэмж, гаалийн татвар дунджаар 52 хувь, хамгийн ихдээ 57 хувь болсон. АНУ Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орох хүртэл энэхүү дайн нь 100 гаруй жил үргэлжилсэн гэж эдийн засагчид үздэг.⁷

3. АНУ-аас эхлэлтэй дэлхийн худалдааны дайн: АНУ 1930 онд Смүүт-Хавлейгийн хуулийг баталж, гаалийн татварыг дунджаар 59.1 хувь болгосон. Үүний эсрэг дэлхийн ихэнх улс орон гаалийн татвараа нэмсэний зэрэгцээ импортын хориг арга хэмжээ авч, ханшийн зохицуулалт хийж эхэлсэн. 1929 оноос 1934 он хүртэл олон улсын худалдаа 66 хувиар буурч,

дэлхийн ДНБ 15 хувиар буурч, дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн их хямрал болжээ.⁸

Өнгөрсөн түүхийн явцад энэ мэт гааль, худалдааны татвараар зэвсэглэсэн том, жижиг олон худалдааны дайн, сөргөлдөөн улс орнуудын хооронд өрнөсөөр ирсэн. Энэ дайнд дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай, олон улсын худалдааны гол валютыг өмчлөгч АНУ оролцсон тохиолдолд худалдааны дайн олон жил үргэлжилж, дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, улс орнуудад ихээхэн хохирол учруулдаг. Дэлхийн эдийн засаг өнөөдөр ч энэ бодит нөхцөл байдалтай тулгараад байгаа билээ.

Хоёр. АНУ-Хятадын худалдааны дайны өрнөл:

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж эхлэнгүүтээ л протекционист бодлогын тухай ярьж, ялангуяа Хятадыг ил тодоор шүүмжилж байв.⁹ “Америк эн тэргүүнд” (America First) бодлого баримталдаг Д.Трамп ерөнхийлөгч болсны дараа өөрийн зөвлөх, Цагаан ордны худалдаа, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Питер Наваррогийн “худалдааны аюулгүй байдлын бодлого”-ыг дэмжин, ажил хэрэг болгож эхлэсэн юм.¹⁰

“Худалдааны аюулгүй байдлын

бодлого” гэдэг нь аливаа улс өөр улстай худалдаа эрхлэн ашиг хонжоо олж байвал, тухайн улс нь ашиг хонжоо ологч улсыг “дайсан” улс хэмээн үзэж болно гэсэн үзэл санаа юм. Өөрөөр хэлбэл, ашиг хонжоо ологч улс нь тухайн улсыг шууд бусаар, эдийн засгийн арга замаар эзлэхийг оролдож байна гэх хардалтаас үүдэлтэй. Тодруулбал, БНХАУ нь АНУ-аас худалдааны ашиг хонжоо олж байгаа нь АНУ-ыг эдийн засгаар нь дамжуулан эзлэн түрэмгийлэх гэсэн арга бөгөөд Д.Трамп ердөө л эх орноо

7 Shelly P. Battram “Canada-United States Trade Negotiations: Continental Accord or a Continent Apart?” *International Trade Lawyer*

8 I. M. Destler “America’s Uneasy History with Free Trade” *Harvard Business Review* (April 28, 2016)

9 “[미국대선] 트럼프 "대통령 되면 중국 교역길 막을 것" <https://www.ajunews.com/view/20160825075834594>

10 Московский центр Карнеги “Carnegie Moscow Center (Россия): от блицкрига к окопам. Почему Китай отказался уступать в торговой войне с США” https://inosmi.ru/politic/20190522/245127014.html?fbclid=IwAR1I7j062T22_sT64lY0w1EMraJ41pgBIZYoqjXrXzTPzdXdHAX6j-lx6AI

хамгаалахын тулд зохих арга хэмжээ авсан гэж тайлбарлаж буй хэрэг. АНУ үлэмж их хэмжээний гадаад худалдааны алдагдал хүлээдэг, үүнээс Хятадтай хийх худалдаанаас хүлээх алдагдал нь толгой цохиж байгаа нь “Америкийг эн тэргүүнд тавих” үзэлтний хувьд тэвчишгүй зүйл болж байв. Худалдааны дайн үүсэх нэг албан ёсны шалтгаан нь энэ юм.

2018 оны 7 дугаар сарын 6-ны өдөр АНУ урьдчилан сануулж байсныхаа дагуу БНХАУ-ын 818 нэр төрлийн 34 тэрбум доллартай тэнцэх импортын бараанд 25 хувийн гаалийн татвар ноогдуулахаа албан ёсоор зарласан. Энэ мэдэгдлийн дараа Хятад улс “үндэсний эрх ашиг, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд шаардлагатай хариу арга хэмжээ авахаас өөр гарцгүй боллоо” хэмээн АНУ-аас импортолдог газар тариалангийн бүтээгдэхүүн, авто машин, далайн бүтээгдэхүүнд яг адилхан буюу 25 хувийн гаалийн татвар ноогдуулжээ. Ингэж хоёр улс худалдааны дайн эхлүүлсэн юм.

БНХАУ нь АНУ руу 550 тэрбум орчим ам.долларын бараа бүтээгдэхүүн экспортолдог. Үүнээс 250 орчим тэрбум доллар буюу нийт Хятадаас авч байсан барааны 50 орчим хувьд АНУ гаалийн албан татвар ноогдуулсан. Мөн худалдааны дайн цаашид ч үргэлжилсээр байвал Хятадаас импортолдог бүх бараа бүтээгдэхүүний тарифыг нэмнэ хэмээн мэдэгдэж байв. Харин БНХАУ нь АНУ-аас 180 гаруй тэрбум долларын бараа бүтээгдэхүүн

импортолдог, үүнийхээ 110 тэрбум буюу 61.1 хувьд ноогдох гаалийн татварыг аль хэдийнэ нэмээд байсан юм.¹¹

Зураг 1. АНУ-БНХАУ-ын худалдааны дайны өрнөл¹²



Гаалийн татвараар нэгнээ давах гэсэн тулаанд АНУ илт давуу байр суурьтай байсны дээр Хятадыг гарцаагүй байдалд оруулахын тулд тус улсын технологийн шилдэг компани болох Хуавэй компанийг онилсон. Ингээд АНУ тус компанийг Хятадын засгийн газартай нягт холбоотой ажилладаг, тоног төхөөрөмжөө тагнуулын зорилгоор ашигладаг байж магадгүй хэмээн болгоомжилж буйгаа мэдэгдсэн юм. Үүнээс үүдэн, 2019 онд баталсан АНУ-ын Үндэсний батлан хамгаалах тухай хууль (National Defense Authorization Act)-ийн 889

11 Minghao Li (2018) CARD Trade War Tariffs Database. <https://www.card.iastate.edu/china/trade-war-data/>

12 Мөн тэнд

дүгээр зүйлд заасны дагуу Хятадын Хуавэй, ZTE гэсэн хоёр компанийн тоног төхөөрөмжийг АНУ-ын төрийн байгууллагуудад ашиглахыг хориглох тухай зарлигт Ерөнхийлөгч Д.Трам 2019 оны 8 дугаар сард гарын үсэг зурсан билээ.¹³

Мөн Хуавей компанийн тоног төхөөрөмж нь АНУ-ын аюулгүй байдалд харшилж байна хэмээн зарлаж, Америкийн компаниуд тус компанитай хамтран ажиллахад тусгай зөвшөөрөл авах шаардлагатай хэмээн тогтоосон. Уг шийдвэрт захирагдан Google, Microsoft, Intel, ARM, Qualcomm, Broadcom зэрэг АНУ-ын мэдээлэл технологийн салбарын тэргүүлэгч компаниуд тус компанид программ хангамж, технологи, тоног төхөөрөмж нийлүүлэхээ зогсоосон. АНУ-ын энэ шийдвэрээс болж Хуавэй хар жагсаалтад орж, ганц АНУ төдийгүй дэлхийн бусад орнуудын компаниуд ч хамтран ажиллахаас татгалзаж эхэлсэн. Японы Soft Bank группын харьяа ARM буюу дэлхийн зах зээлийн 90 хувийг эзэгнэдэг хагас дамжуулагчийн бүтэц зургийн компани, Панасоник, Тошиба компани ч Хуавэй компанитай хамтран ажиллахаас татгалзав. Мөн Америкийн Амазон компани тус компанийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулахаас татгалзсанаа албан ёсоор зарласан.¹⁴

Худалдааны дайн үргэлжилсэн

тохиолдолд бай болох компани зөвхөн Хуавэй компаниар дуусахгүйг битүүхэн сануулж, АНУ-ын зүгээс “Хятадад үйлдвэрлэсэн дронууд АНУ-ын мэдээллийг нууцаар дамжуулж байх магадлалтай” хэмээх тодорхойгүй мэдэгдэл хийсэн байдаг. Энэ нь хятадын томоохон технологийн компани, дэлхийн дрону зах зээлд чухал байр суурь эзэлдэг DJI-ийг дайруулан хэлсэн хэрэг юм.¹⁵ Ийнхүү худалдааны дайн өргөжин технологийн дайн болж даамжирсан.

АНУ-БНХАУ-ын худалдааны I шатны хэлэлцээр:

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трам, БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч Лю Хө нар АНУ-БНХАУ-ын худалдааны “эхний үе шаг”-ны хэлэлцээрт 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр гарын үсэг зурав¹⁶. Энэ нь 2018 оны 3 дугаар сараас хойш АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын гаргасан Хятадын худалдааг гажуудуулж буй талаархи 301 тоот мөрдөн шалгах ажиллагааг нийтэлснээс хойш үргэлжилж буй худалдааны хурцадмал байдлыг арилгах хүчин чармайлтын нэг хэсэг юм хэмээн АНУ-ын тал тайлбарласан. Ирэх хоёр жилийн хугацаанд Хятад нь 4 салбар (аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, ХАА-н бүтээгдэхүүн, эрчим хүч)-т 2017 оны

13 “UPDATE: Huawei Ban And Section 889 Representation Requirements” <https://www.jdsupra.com/legalnews/update-huawei-ban-and-section-889-49395/>

14 Nikkei Asia “Amazon Japan halts direct sales of Huawei devices” (May 24, 2019) <https://asia.nikkei.com/Spotlight/Huawei-crackdown/Amazon-Japan-halts-direct-sales-of-Huawei-devices>

15 Dronelife “Trump’s Tariffs Passed on to DJI Customers” (Sep 4, 2019) <https://dronelife.com/2019/09/04/trumps-tariffs-passed-on-to-dji-customers/>

16 Reuters “What’s in the U.S.-China Phase 1 trade deal” (Jan 16, 2020) <https://www.reuters.com/article/us-usa-trade-china-details-factbox-idUSKBN1ZE2IF>

түвшнээс 200 тэрбум ам.доллараар илүү бараа бүтээгдэхүүнийг нэмж худалдан авах үүрэг хүлээсэн. Тодруулбал, БНХАУ нь 77.7 тэрбум ам.долларын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, 52.4 тэрбум ам.долларын эрчим хүч, 32.9 тэрбум ам.долларын ХАА-н бараа бүтээгдэхүүн, 37.6 тэрбум ам.долларын үйлчилгээг нэмж худалдан авах үүрэг хүлээлээ. Энэхүү хэлэлцээрт ангилал тус бүрд тодорхой бүтээгдэхүүнийг нарийвчилан заасан хавсралтыг оруулсан.¹⁷

Үүний хариуд, Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа Хятадын 120 тэрбум ам.доллартай тэнцэх бараа бүтээгдэхүүнд ноогдуулахаар зарлаад байсан АНУ-ын импортын татварыг 15 хувиас 7.5 хувь болгон бууруулахаар болсон. I үе шатны хэлэлцээр 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болоход 2019 оны 9 дүгээр сард ногдуулсан энэхүү тарифыг бууруулах амлалтыг Вашингтон авсан. Яриа хэлэлцээ өрнөж байх үед, 2019 оны 12 дугаар сарын дунд үеэс хэрэгжиж эхлэх ёстой байсан АНУ-аас авдаг 180 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд ноогдуулсан тарифыг бууруулахаар 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр зарласан. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Гаалийн тарифын комисс 12 дугаар сарын дунд үеэс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байсан нэмэлт тарифаа хойшлуулж, АНУ-ын автомашины экспортод

дахин ноогдуулахаар төлөвлөж байсан тарифаа түр зогсоосон.

Мөн Хятадын тал мөнгөн тэмдэгтийнхээ ханшийг зориудаар доогуур тогтоохгүй, гадаад орнуудын оюуны өмчийг хамгаалах, гадаадын компаниудаас технологи дамжуулахыг шаардахгүй байх үүрэг хүлээсэн.¹⁸ Худалдааны нууцыг хадгалах тухайд, худалдааны нууцыг зүй бусаар ашигласан тохиолдолд хоёр талын аль аль нь хариуцлага хүлээхээр тохирсон юм. Гэрээгээр БНХАУ нь худалдааны нууцыг зүй бусаар ашиглахтай холбоотой тодорхой үйл ажиллагааг тусгайлан зааж өгсний дотор электрон байдлаар худалдааны нууцад халдах, тодорхой мэдээллийг задруулахгүй байх үүргээ зөрчих буюу зөрчихийг өдөөн турхирах, худалдааны нууцыг зөвшөөрөлгүй задруулах буюу ашиглах зэргийг хамруулсан байна. БНХАУ нь ийнхүү худалдааны нууцыг зүй бусаар ашиглахтай холбоотой эдгээр үйл ажиллагааг тодорхойлсноор, АНУ-д хэрэгжиж буй Худалдааны хуулийн тухай нэгдсэн хууль, Худалдааны нууцыг хамгаалах тухай хуультай нийцсэн байдлаар худалдааны нууцыг хамгаалахаар болж байна.

Түүнчлэн худалдааны нууцтай холбоотой асуудлаарх шүүхийн тусгайлсан процесст өөрчлөлт оруулахыг БНХАУ-ын тал зөвшөөрсөн юм. Нэгдүгээрт, буруутгагдаж буй талыг худалдааны нууцыг зүй бусаар

17 Thomas Franck, CNBC “Here’s what China agreed to buy from the US in the phase one trade deal” (Jan 15, 2019) <https://www.cnbc.com/2020/01/15/heres-what-china-agreed-to-buy-from-the-us-in-the-phase-one-trade-deal.html>

18 Virgil Bisio, Charles Horne, Ann Listerud, Kaj Malden, Leyton Nelson, Nargiza Salidjanova & Suzanna Stephens, The U.S.-China Economic and Security Review Commission, “The U.S.-China “Phase One” Deal: A Backgrounder” (February 4, 2020) <https://www.uscc.gov/sites/default/files/2020-02/U.S.-China%20Trade%20Deal%20Issue%20Brief.pdf>

ашигласан гэдгийг шууд буюу хоёрдугаар зэргийн шинж чанартай нотолгооны үндсэн дээр нууц эзэмшигч тал нь нотолсон тохиолдолд, худалдааны нууцыг зүй бусаар ашиглаагүй гэдгээ иргэний процесст нотлох үүрэг нь буруутгагдаж талд шилжихээр болсон. Мөн Хятадад худалдааны нууцын хулгай (юмуу эсвэл ийм нөхцөл үүсэх эрсдэл байх)-тай холбогдуулан шүүхээр хамгаалуулах тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэр гарна. Эцэст нь, худалдааны нууцыг зүй бусаар ашигласан тухайд иргэний хэрэг үүсгэн, ял шийтгэл ноогдуулж болох бөгөөд худалдааны нууцыг эзэмшигч тал нь эрүүгийн хэргийн ийм мөрдлөгийг эхлүүлэх урьдач нөхцөл болгон бодит алдагдалд орсон байх шаардлагагүй юм.

Энэ гэрээний нэг чухал хэсэг нь Хятадад бизнес эрхэлж буй гаднын компаниуд оюуны өмчөө дамжуулах юмуу эсвэл лицензийг өгөх үүрэгтэй байгаа практикийг халахад томоохон дэвшил гаргасан юм. Тодруулбал, гэрээний хоёрдугаар хэсэгт зааснаар, АНУ болон Хятадын хооронд явагдах технологи дамжуулах буюу түүний лицензийг өгөх үйл ажиллагаа нь “ямар нэг хүч буюу дарамт шахалтгүй”-гээр явагдах бөгөөд сайн дурын, хамтын гэрээнд суурилсан зах зээлийн

зарчмаар явагдана. Технологийг дамжуулах нь тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, компани худалдан авах, хамтран компани байгуулах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай урьдач нөхцөл болгохгүй байхад чиглэсэн захиргааны болон лицензийн шаардлагыг бий болгохоор тохиролцсон юм.¹⁹

Энэхүү хэлэлцээр байгуулагдснаас хойш 6 сарын дараа буюу 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдөр АНУ-ын Худалдааны төлөөлөгч Роберт Лайтхайзер, БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч Лю Хө нарын тэргүүлсэн албаныхан хэлэлцээрийн хэрэгжилтийг авч үзэх видео хурлыг хийсэн. Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг уналтад орсноор БНХАУ эхний жилийн зорилт болох импортоо 77 тэрбум ам.доллараар нэмэгдүүлж чадаагүй байна. ХАА-н бүтээгдэхүүний тухайд 2020 онд хүрэх ёстой зорилт болох 36.5 тэрбум ам.долларт хүргэж 50 хувиар нэмэгдүүлж чадаагүй буюу 2017 оны түвшнээс ч бага байна. Эрчим хүчний бүтээгдэхүүний тухайд эхний жилийн зорилт болох 25.3 тэрбум ам.долларын барааны ердөө 5 хувийг нь худалдан авсан байна.²⁰

19 GreenbergTraurig “Impact of the China-U.S. Trade Deal on Intellectual Property Protection” (Jan 21, 2020) <https://www.gtllaw.com/en/insights/2020/1/impact-of-the-china-us-trade-deal-on-intellectual-property-protection>

20 Peterson Institute for International Economics “US-China phase one tracker: China’s purchases of US goods” <https://www.piie.com/research/piie-charts/us-china-phase-one-tracker-chinas-purchases-us-goods>

Гурав. АНУ-Хятадын худалдааны дайны нөлөө:


Худалдааны дайн тус хоёр улсын эдийн засагт аль алинд нь сөргөөр нөлөөлсөн. Ерөнхийлөгч Д.Трамп худалдааны дайны талаар: “АНУ нь Хятадтай хийж байсан худалдаанд жил бүр алдагдал хүлээж байсан бөгөөд нийт худалдааны алдагдалын хэмжээ нь 375.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ алдагдлыг нөхөж, дахин үүсэхгүй байх, эдийн засгийн өсөлтийг хурдасгахад чиглэсэн” хэмээн албан ёсоор тайлбарласан бөгөөд энэ нь үр дүнд хүрч 2018 оны сүүлийн хагасын байдлаар Америкийн эдийн засгийн өсөлт 2014 оноос хойш анх удаа 4.1 хувьд хүрсэн.²¹ Харин Хятадын хувьд өмнөх хагастай харьцуулахад эдийн засгийн өсөлт буурч 6.7 хувьд хүрсэн байна.²² Харин 2019 он гарч худалдааны дайн дахин нэг жил үргэлжилснээр, нөхцөл байдал өөрчлөгдөн, компаниуд, тариаланчдын амьдралд сөргөөр нөлөөлж, аль

аль талынх нь эдийн засгийн өсөлт улам буурсаар байна. Цагаан ордны мэдээллэж байгаагаар энэ дайн хэлэлцээрт хүрч чадалгүй үргэлжилвэл Америкийн эдийн засгийн өсөлт 1 хувиар буурсан гэсэн тооцоо байсан.²³

2019 онд Америкийн Хятадаас авдаг импорт 2018 онтой харьцуулахад нэлээд буурсан. Харин эсрэгээрээ, Европын холбооны орнуудын Америкийн зах зээлд эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн (Зураг 2-ыг үзнэ үү). Ийнхүү худалдааны урсгалд өөрчлөлт гарсан нь Америкийн худалдааны алдагдалд төдийлөн нөлөөлөөгүй. Өөрөөр хэлбэл, дайн сунжирсны улмаас Америкийн худалдааны алдагдал худалдааны дайнаас өмнөхтэй бараг адил ДНБ-ий 3 хувьтай тэнцсэн хэвээр байв.

Мүүдис Аналитиксын 2019 оны 9 дүгээр сард хийсэн судалгаанаас үзэхэд, худалдааны дайны улмаас АНУ-д 300,000 ажлын байр үгүй болж,

Зураг 2. АНУ-ын импорт



АНУ-ын Тоо бүртгэлийн тооцоо

21 미중 무역전쟁 4개월...경제지표는미국이 '한판승' <https://www.yna.co.kr/view/AKR20180810134100009>

22 <https://blog.naver.com/danmass/221562476477>

23 미중무역전쟁 '미국경제 성장률 1%이상 낮춘다' <http://korusnews.com/>

худалдааны дайнаас хүлээх хохирол бодит ДНБ-ий 0.3 хувьтай тэнцэж байв.²⁴ Бусад судалгаанд тооцноор, худалдааны дайн нь АНУ-ын ДНБ-ний ойролцоогоор 0.7 хувьтай тэнцэх хэмжээний хохирол учруулжээ.²⁵ Блүүмберг Экономиксийн 2019 оны тайланд дурдснаар, 2020 оны эцэс гэхэд худалдааны дайнаас үүдэн Америкийн эдийн засаг 316 тэрбум ам.долларын алдагдал хүлээхээр байгаа²⁶ бол Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк, Колумбийн их сургуулийн хамтарсан сүүлийн судалгаагаар, АНУ-ын зүгээс БНХАУ-ын экспортод тавьсан тарифын улмаас Америкийн компаниуд хамгийн багадаа 1.7 их наяд ам.долларын алдагдал хүлээсэн байна.²⁷ Үндсэндээ худалдааны дайны улмаас тогтоосон тарифын зардлыг Америкийн компаниуд үүрч,²⁸ нийтдээ 46 тэрбум ам.долларыг төлсөн болох нь олон тооны судалгаанаас харагдаж байна.²⁹ Тарифын улмаас Америкийн аж ахуйн нэгжүүд ашгаа хамгийн доод түвшинд барих, ажилчдын цалин хөлсийг бууруулах, ажлын байрыг цомхотгох,

цалин хөлсийг нэмэгдүүлэхээ хойш нь тавих болсон төдийгүй Америкийн хэрэглэгчдийн гарт очих бараа бүтээгдэхүүний өртөг зардал нэмэгдсэн. АНУ-ын ноогдуулсан тарифын хариу болгож БНХАУ-ын авсан арга хэмжээний улмаас Хятад руу гаргадаг байсан 24 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүний зах зээлийн дийлэнх хувийг алдсан гэж Америкийн фермерийн товчооны хэвлэлийн төлөөлөгч мэдэгджээ.³⁰

Жил гаруй хугацаанд үргэлжилсэн худалдааны дайн нь Хятадын хөгжлийг сааруулж, гадаад худалдаа нь буурахад хүргэсэн гэх тооцоог Финландын төв банкнаас гаргасан байна. Ялангуяа, 2019 онд Хятадын импорт өмнөх онтой нь харьцуулахад буурсны дотор Хятадын Америкаас авдаг импортын бараа бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны 7 дугаар сард 25 хувиар огцом буурчээ. Худалдааны дайны нөлөөгөөр эрэлт буурч, үйлдвэрлэлийн гинжин хэлхээ тасалдснаас Хятадын хөрш орнуудаас нийлүүлэх гадаад худалдааны урсгал багасгах болов.³¹ Мөн АНУ-

24 Moody's Analytics "Trade War Chicken: The Tariffs and Damage Done" (Sep 2019) <https://www.moodyanalytics.com/-/media/article/2019/trade-war-chicken.pdf>

25 Bloomberg Economics "Trump's China Buying Spree Unlikely to Cover Trade War's Costs" (Dec 19, 2019) <https://www.bloomberg.com/news/articles/2019-12-18/trump-s-china-buying-sprees-unlikely-to-cover-trade-war-s-costs>

26 Мөн тэнд

27 Federal Reserve Bank of New York, University of Columbia "The Impact of the 2018 Trade War on U.S. Prices and Welfare" (May 13, 2019) <https://www.nber.org/papers/w25672.pdf>

28 Andrea Shalal, Reuters "Trump's tariffs cost U.S. companies \$46 billion to date, data shows" (January 10, 2020) <https://www.reuters.com/article/us-usa-trade-economy/trumps-tariffs-cost-u-s-companies-46-billion-to-date-data-shows-idUSKBN1Z8222>

29 The National Bureau of Economic Research "Who's Paying for the US Tariffs? A Longer-Term Perspective" (January 2020) <https://www.nber.org/papers/w26610>

30 The Hill "Businesses, farmers brace for new phase in Trump trade war" (Aug 8, 2019) <https://thehill.com/policy/finance/trade/456640-businesses-farmers-brace-for-new-phase-in-trump-trade-war>

31 Bank of Finland "The trade war has significantly weakened the global economy" (Nov 12, 2019) <https://www.bofbulletin.fi/en/2019/4/the-trade-war-has-significantly-weakened-the-global-economy/#okfmvHu3TZuMaXyou4mOOQ-reference-text-5>

ын Худалдааны танхимын хийсэн судалгаанд оролцсон, Хятадад үйл ажиллагаа явуулж байгаа Америкийн компаниудын 40 хувь нь үйлдвэрлэлээ Азийн бусад зах зээл юмуу эсвэл Мексик шилжүүлэхийг сонирхох болов. Учир нь Хятадад үйлдвэрлэл явуулдаг Америкийн 4 компани тутмын 1-д нь Америк, Хятадын бие биендээ тавьсан тариф сөрөг нөлөө үзүүлсэн байна.³²

АНУ тарифаа нэмэгдүүлсэнтэй холбогдуулан БНХАУ-ын зүгээс мөнгөн тэмдэгийнхээ ханшийг ялимгүй сулруулах арга хэмжээ авснаар валютын зах зээл дээр Хятадын юанийн ханш суларсан байна. Худалдааны дайны тухай мэдээ тархснаар санхүүгийн зах зээлд түгшүүр төрүүлж, хөрөнгийн зах зээл дээр савлагаа үүсгэсэн. Ялангуяа, шинээр гарч ирж буй эдийн засгууд, түүний дотор Хятадын хөрөнгийн зах зээлд худалдааны дайны сөрөг нөлөө илэрхий мэдрэгдэж байв. 2019

оны 5 болон 8 дугаар сард болсон худалдааны хэлэлцээртэй зэрэгцэн зээлийн эрсдлийн үнэ өссөн. Шинээр гарч ирж буй эдийн засгуудад 2018 оны эхнээс эхлэн эрсдлийн үнэ бага зэрэг нэмэгдсэн боловч дэлхийн зах зээлийн хувьд ерөнхийдөө дундаж түвшинд байв.³³

Худалдааны дайн нь дэлхийн эдийн засагт ихээхэн хохирол үзүүлж, улс хоорондын экспортын хэмжээг бууруулж, корпорацуудын ашиг багасч, үүнээс улбаалан дэлхийн ДНБ буурдаг. Мөн гаалийн татварыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлнэ. Олон улсын гаалийн татвар нэг хувиар нэмэгдэхэд улс орнуудын ДНБ харилцан адилгүй буурах бөгөөд үүний дотор БНСУ болон ХБНГУ-ын ДНБ 0.65 болон 0.48 хувиар буурдаг гэсэн тооцоо бий. Өөрөөр хэлбэл, тус хоёр улс АНУ-Хятадын худалдааны дайны хөлд хамгийн их хохирол амсах улс гэсэн үг юм³⁴ (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Америкийн компаниуд Хятадаас

Хүснэгт 1. Олон улсын гаалийн татвар 1 хувиар нэмэгдэхээс хамаарч улс орнуудын ДНБ-ий бууралт

Улс	ДНБ-ий бууралт	Улс	ДНБ-ий бууралт
БНСУ	-0.65	Итали	-0.19
ХБНГУ	-0.48	Их Британи	-0.19
Япон	-0.33	БНФУ	-0.15
БНХАУ	-0.27	АНУ	-0.13

Эх сурвалж: ОУВС

32 AmCham China, AmCham Shanghai “Second Joint Survey on the Impact of Tariffs” (May 19, 2019) <https://www.amchamchina.org/about/press-center/amcham-statement/second-joint-survey-on-the-impact-of-tariffs>

33 Bank of Finland “The trade war has significantly weakened the global economy” (Nov 12, 2019) <https://www.bofbulletin.fi/en/2019/4/the-trade-war-has-significantly-weakened-the-global-economy/#okfmvHu3TZuMaXyou4mQOQ-reference-text-5>

34 "미중무역전쟁 타격, 한국이 가장 커" <https://mk.co.kr/news/economy/view/2019/04/207115/>

өөр боломжит импортлогчийг олж чадвал АНУ-ын Хятадаас хамаарах хамаарлыг бууруулж чадна. Өнгөрсөн жилийн тухайд Америк нь Хятадаас авдаг байсан бараа бүтээгдэхүүнээ өөр улсаас нийлүүлэх замаар хэрэгцээгээ хангахыг оролдсон боловч энэ зорилгоо бүрэн биелүүлж чадсангүй. АНУ-ын зүгээс тарифаа нэмэгдүүлсэн бараа нь 2018 оны эхний хагаст 130 орчим тэрбум ам.доллар байсан бол 2019 оны эхний хагаст 95 тэрбум ам.доллар болж буурснаас үзэхэд АНУ-ын БНХАУ-аас авдаг импорт 35 тэрбум ам.доллар (25 орчим хувь)-аар буурсан байна. Тэрхүү 35 тэрбум ам.долларын импортын алдагдлын 21 тэрбумыг нь бусад орноос авах импортоор нөхсөн бол АНУ-ын эрэлтээ бууруулсан эсвэл дэлхийн бусад орноос нийлүүлэх боломжгүй гэх шалтгаанаар үлдэх 14 тэрбум ам.долларын барааны эрэлт нөхөгдөөгүй байна. Мөн үүнээс хийх нэг чухал дүгнэлт нь хэдийгээр БНХАУ тарифын өсөлтөнд өртсөн ч гэсэн АНУ-тай хийх худалдааныхаа 75 хувийг хэвээр хадгалж чадсан байна.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын гаргасан тайланд дурдснаар, хоёр улсын худалдааны дайнаас хамгийн их ашиг хүртсэн нь Хятадын Тайвань бөгөөд 2019 оны эхний хагаст 4.2 орчим тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнийг АНУ руу нэмж нийлүүлжээ. Тайваний оффисын болон харилцаа холбооны тоног төхөөрөмжийн экспортод өсөлт


гарснаар АНУ руу нийлүүлэх бараа бүтээгдэхүүний хэмжээ нь нэмэгджээ. Худалдааны дайнаас ашиг хүртэгсдийг тэргүүлэх хоёрдахь улс нь Мексик юм. Тус улсын хувьд Хятадын нийлүүлдэг байсан хүнс, тээврийн хэрэгсэл, электрон машин механизмын салбарт хамаарах бараа бүтээгдэхүүнийг түлхүү нийлүүлж, АНУ-ын зах зээлээс нэмээд 3.5 тэрбум ам.долларыг олох боломжтой болов. Европын Холбоо ч Америкийн зах зээлээс 2.7 тэрбум ам.долларыг “халааслаж” чадсан нь машин тоног төхөөрөмжийн худалдаанаас үүдэлтэй юм. Өмнөд Солонгос, Канад, Энэтхэгийн тухайд худалдааны дайнаас 0.9-аас 1.5 тэрбум ам.долларын ашиг хүртсэн нь чамлахааргүй үзүүлэлт юм. Өмнөд Азийн бусад орнууд нийлээд 1.7 тэрбум ам.долларын худалдааг АНУ-тай хийсэн бол Латин Америк, Саб Сахарын орнууд болон дэлхийн бусад орон төдийлөн ашиг хүртэж чадаагүй байна.³⁵

АНУ-ын Холбооны нөөцийн сангийн судалгаагаар, худалдааны дайны нөлөөгөөр Мексик улс АНУ руу гаргах экспортоо нэмэгдүүлснээр ДНБ-ээ өсгөж хамгийн их ашиг хүртэж чаджээ (Зураг 3-ыг үзнэ үү). Харин Хятадын эрэлт буурснаар тус улсад түүхий эд нийлүүлдэг Шинэ Зеланд, Чили, Өмнөд Африк зэрэг улсын бодит ДНБ-д сөргөөр нөлөөлж, бууралт ажиглагдахад нөлөөлжээ.³⁶

35 Alessandro Nicita “Trade and trade diversion effects of United States on China” UNCTAD Research Paper No. 37 UNCTAD/SER.RP/2019/9

36 John K. Ferraro and Eva Van Leemput, Board of Governors of the Federal Reserve System “Long-Run Effects on Chinese GDP from U.S.-China Tariff Hikes” (July 15, 2019) <https://www.federalreserve.gov/econres/notes/feds-notes/long-run-effects-on-chinese-gdp-from-us-china-tariff-hikes-20190715.htm>

Зураг 3. Бусад улсад худалдааны дайны нөлөөлсөн байдал



Харин Японы Номура санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компанийн тооцоогоор, худалдааны дайны нөлөөгөөр Америкийн Вьетнамаас авах импорт нэмэгдснээр, тус улсын ДНБ 7.9 хувиар өсч, энэ тэмцлээс хамгийн их ашиг хүртжээ. Дараагийн байруудад орсон Чили, Малайз, Аргентиний тухайд Хятадын импорт нэмэгдснээр худалдааны дайнаас ашиг хүртсэн байна. Нийтдээ, гуравдагч орнууд Хятад руу нэмж экспортлохоос илүүтэй

АНУ руу Хятадын экспортыг орлосон бүтээгдэхүүнийг гаргаснаар илүү ашиг хүртсэн байна. Азийн дэлхийн өртгийн гинжин сүлжээ (Хятадыг эс тооцвол) АНУ-ын импортыг орлох замаар илүү их ашиг олж байсан бол (АНУ-ыг эс тооцвол) Хятад импортыг орлох замаар илүү их ашиг олжээ. Европ дахь хамгийн том ашиг хүртэгч нь Франц боловч бүс нутгийн нийт ашиг нь бага хэмжээтэй байна.³⁷

Дүгнэлт

Дэлхийн II дайнаас хойш улс үндэстнүүд чөлөөт худалдааны бодлого баримтлах ерөнхий хандлага давамгайлж байсан боловч өөрийн улс орны эрх ашгийг эн тэргүүнд тавих үзлээс үүдэлтэйгээр худалдааны протекционист бодлогыг баримталдаг улс үндэстнүүд байсаар байна. Энэ

бодлогыг шууд буруушаах аргагүй боловч ихэнх худалдааны дайн үүнээс үүдэн гардаг.

Дэлхийн худалдааны байгууллага нь чөлөөт худалдааны бодлогыг дэмжиж, олон улсын худалдаа, эдийн засгийн аюулгүй байдлыг ханган ажилладаг боловч дэлхийн хүчирхэг

37 Nomura “US-China trade diversion: Who benefits?” (June 2019) <https://www.nomuraconnects.com/ocused-thinking-posts/us-china-trade-diversion-who-benefits/>

гүрнүүдийн эдийн засгийн хатуу бодлогын өмнө хүчин мөхөстөж байгааг АНУ-БНХАУ-ын худалдааны дайн харуулж байна.

“Америк эн тэргүүнд” үзлийг баримтлагч Д.Трампын Хятадын талд эдийн засгийн болоод улс төрийн хохирлын аль алиныг нь амсуулахыг зорьсон. Эдийн засгийн тухайд гаалийн татварыг нэмэгдүүлэх, технологийн хориг тавих замаар Хятадад цохилт үзүүлсэн бол Тайвань, Хонгконгт дэмжлэг үзүүлэн улс төрийн дарамт учруулж Хятадыг буулгаж авахыг зорьж байна.

Харин Хятадын тал худалдааны дайнаас үүдсэн эдийн засгийн хохирлыг даван туулах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд харин улс төрийн бодлогод шууд нөлөөлөх гэсэн хандлагыг нь хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ хэлэлцээр болгонд ил далд утгаар илэрхийлсээр ирсэн. Хоромхон зуурын цахилгаан дайн бүтэлгүйтсэний дараа нуувчны зууралдсан хүнд тулалдаан эхэлдэг нь жам ёс, гэхдээ эцсийн дүндээ энэ бүхэн эвлэрлээр төгсөх нь дамжиггүй байсан юм.

Энэ ч ёсоор хоёр талын 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр худалдааны дайнаа эцэслэх эхний үе шатны хэлэлцээрийг байгуулсан

юм. Энэ хэлэлцээрийн хүрээнд талууд харилцан ноогдуулсан татваруудынхаа заримыг нь цуцалсны зэрэгцээ Хятадын талын тухайд оюуны өмчийг хамгаалах, Америкийн компаниуд тус улсад бизнес эрхлэхэд технологи шилжүүлэхийг “хүчээр” тулгахгүй байх амлалтыг авсан билээ. Улмаар 6 сарын дараа хэлэлцээрийн хэрэгжилтийг хянаж үзсэн боловч Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засагт учирсан хүндрэлийн уршгаар Хятадын тал хүлээсэн үүргээ буюу эхний жилдээ Америкаас худалдан авах ёстой хэмжээндээ хүрч чадаагүй гэх дүгнэлт гараад байна. Хятадын тал хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй тохиолдолд худалдааны дайн дахин хурцдах магадлалтай юм. Гэвч энд улс төрийн хүчин зүйл буюу АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуулийн үр дүн нөлөөлнө гэдгийг бас тооцох хэрэгтэй юм. Хэдийгээр сонгуульд Ардчилсан намаас дэвшиж ялалт байгуулсан Жозе Байден тухайд ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд худалдааны дайныг зогсооно хэмээн мэдэгдээгүй боловч түүний засаглалын үед АНУ-ын байр суурь зөөлрөх магадлалтай хэмээн судлаачийн хувьд дүгнэж байна.

Ашигласан материал

1. Alessandro Nicita “Trade and trade diversion effects of United States on China” UNCTAD Research Paper No. 37 UNCTAD/SER.RP/2019/9
2. AmCham China, AmCham Shanghai “Second Joint Survey on the Impact of Tariffs” (May 19, 2019) <https://www.amchamchina.org/about/press-center/amcham-statement/second-joint-survey-on-the-impact-of-tariffs>
3. Andrea Shalal, Reuters “Trump’s tariffs cost U.S. companies \$46 billion to date, data shows” (January 10, 2020) <https://www.reuters.com/article/us-usa-trade-economy/trumps-tariffs-cost-u-s-companies-46-billion-to-date-data-shows-idUSKBN1Z8222>
4. Bank of Finland “The trade war has significantly weakened the global economy” (Nov 12, 2019) <https://www.bofbulletin.fi/en/2019/4/the-trade-war-has-significantly-weakened-the-global-economy/#okfmvHu3TZuMaXyou4mQOQ-reference-text-5>
5. Big Think “Mercantilism: The theory that explains Trump’s trade war” <https://bigthink.com/politics-current-affairs/donald-trump-trade-mercantilism?rebelltitem=4#rebelltitem4>
6. Bloomberg Economics “Trump’s China Buying Spree Unlikely to Cover Trade War’s Costs” (Dec 19, 2019) <https://www.bloomberg.com/news/articles/2019-12-18/trump-s-china-buying-spree-unlikely-to-cover-trade-war-s-costs>
7. Federal Reserve Bank of New York, University of Columbia “The Impact of the 2018 Trade War on U.S. Prices and Welfare” (May 13, 2019) <https://www.nber.org/papers/w25672.pdf>
8. GreenbergTraurig “Impact of the China-U.S. Trade Deal on Intellectual Property Protection” (Jan 21, 2020) <https://www.gtlaw.com/en/insights/2020/1/impact-of-the-china-us-trade-deal-on-intellectual-property-protection>
9. John K. Ferraro and Eva Van Leemput, Board of Governors of the Federal Reserve System “Long-Run Effects on Chinese GDP from U.S.-China Tariff Hikes” (July 15, 2019) <https://www.federalreserve.gov/econres/notes/feds-notes/long-run-effects-on-chinese-gdp-from-us-china-tariff-hikes-20190715.htm>
10. JPMorgan “What is a trade war and are in one?” https://am.jpmorgan.com/blob-gim/1383557340865/83456/PI-TRADEWAR_r9.pdf

11. Minghao Li (2018) CARD Trade War Tariffs Database. <https://www.card.iastate.edu/china/trade-war-data/>
12. Moody's Analytics "Trade War Chicken: The Tariffs and Damage Done" (Sep 2019) <https://www.moodyanalytics.com/-/media/article/2019/trade-war-chicken.pdf>
13. Nomura "US-China trade diversion: Who benefits?" (June 2019) <https://www.nomuraconnects.com/ocused-thinking-posts/us-china-trade-diversion-who-benefits/>
14. Peterson Institute for International Economics "US-China phase one tracker: China's purchases of US goods" <https://www.piie.com/research/piie-charts/us-china-phase-one-tracker-chinas-purchases-us-goods>
15. Review "Global trade war: the background, the theory, winners and losers" (July 24, 2018) <https://apngroup.com.au/blog/global-trade-war-the-background-the-theory-winners-and-losers/>
16. Robert Z. Lawrence, Lawrence Edwards "Shattering the Myths About U.S. Trade Policy", *Harvard Business Review* (March 2012)
17. Robert Z. Lawrence, Roberts E. Litan "Why Protectionism Doesn't Pay", *Harvard Business Review* (May 1987)
18. The National Bureau of Economic Research "Who's Paying for the US Tariffs? A Longer-Term Perspective" (January 2020) <https://www.nber.org/papers/w26610>
19. The Hill "Businesses, farmers brace for new phase in Trump trade war" (Aug 8, 2019) <https://thehill.com/policy/finance/trade/456640-businesses-farmers-brace-for-new-phase-in-trump-trade-war>
20. Thomas Franck, CNBC "Here's what China agreed to buy from the US in the phase one trade deal" (Jan 15, 2019) <https://www.cnbc.com/2020/01/15/heres-what-china-agreed-to-buy-from-the-us-in-the-phase-one-trade-deal.html>
21. Virgil Bisio, Charles Horne, Ann Listerud, Kaj Malden, Leyton Nelson, Nargiza Salidjanova & Suzanna Stephens, The U.S.-China Economic and Security Review Commission, "The U.S.-China "Phase One" Deal: A Backgrounder" (February 4, 2020) <https://www.uscc.gov/sites/default/files/2020-02/U.S.-China%20Trade%20Deal%20Issue%20Brief.pdf>
22. Московский центр Карнеги "Carnegie Moscow Center (Россия): от блицкрига к окопам. Почему Китай отказался уступить в торговой войне с США" https://inosmi.ru/politic/20190522/245127014.html?fbclid=IwAR1I7j062T22_sT64IY0w1EMraJ41pgBlZYojXrXzTPzdXdHAX6j-lx6AI

23. "[미국대선] 트럼프 «대통령 되면 중국 교역길 막을 것» <https://www.ajunews.com/view/20160825075834594>
24. "미중무역전쟁 타격, 한국이 가장 커" <https://mk.co.kr/news/economy/view/2019/04/207115/>
25. 미중 무역전쟁 4개월...경제지표는 미국이 '한판승' <https://www.yna.co.kr/view/AKR20180810134100009>
26. <https://blog.naver.com/danmass/221562476477>
27. 미중무역전쟁 '미국경제 성장률 1%이상 낮춘다' <http://korusnews.com/%EB%AF%B8%EC%A4%91%EB%AC%B4%EC%97%AD%EC%A0%84%EC%9F%81-%EB%AF%B8%EA%B5%AD%EA%B2%BD%EC%A0%9C-%EC%84%B1%EC%9E%A5%EB%A5%A0-1%EC%9D%B4%EC%83%81-%EB%82%AE%EC%B6%98%EB%8B%A4/>

U.S.-China trade war and its impact on the world economy

Byambakhand Luguusharav*

*Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia, byambakhand.l@mas.ac.mn*

Bolormaa Budjav

*Lecturer, Finance Department, Business School, National
University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia
bolormaa.b@num.edu.mn*

Abstracts: *Republican candidate Donald J. Trump, who ran in the 2016 US presidential elections with a slogan “Make America Great Again” defined his foreign policy as “America First”. He set out to balance the long-running deficit of the United States, which led to the US-China trade war. The war not only affected the economies of Washington and Beijing but also it had a devastating effect on the world economy.*

The first part of the article discusses the concept of a trade war, while the second part analyzes the origins, causes, and course of the trade war between the United States and China, and the trade agreement between the two countries that have temporarily stopped the trade war. At the end of the article, the positive and negative implications of the US-China trade war on the economies of both countries and the global economy will be reviewed.

Keywords: *USA, China, trade war, world economy, tariff*

<i>The day of submission:</i>	<i>2020.10.20</i>
<i>Completion of review:</i>	<i>2020.11.01</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2020.11.9</i>

* Corresponding author